

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/030/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх  
Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn  
Ахлах аудитор: Ц.Отгонбаяр  
Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn  
Аудитын гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК  
Утас: 99052418 Цахим хаяг: B.Naranchimeg.POA@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**САНТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ӨЛЗИЙБАДРАХ ТАНАА**

2026.02.25 № СЭА-2026/030/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалттай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Дотуур байр болон үдийн цай хөтөлбөрийн 110,285.6 мянган төгрөгийн хоолны материалын орлого зарлагын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр хийлгүй хүнсний материал гэж бөөн дүнгээр нэгтгэж тайлагнасан,
- Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй,

- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 290.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын ер төлбөр үүсгэсэн,
- Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан,

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сант сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 26,638.2 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ


## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2024.10.01-ийн  
 Төгрөгөөр /  
 81,124,474.80

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4	68,297,706.01	81,124,474.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		68,297,706.01	81,124,474.80
31211	Төрийн сангийн харилцах		68,297,706.01	81,124,474.80
33	<b>АВЛАГА</b>	5	154,130.21	445,044.59
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		154,130.21	445,044.59
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	6	126,632,879.99	131,975,330.49
3546	Хүнсний материал		10,803,655.00	7,008,174.00
3547	Бусад хангамжийн материал		114,115,527.75	124,967,156.49
I	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		195,084,716.21	213,544,849.88
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7	4,968,076,238.04	4,851,040,370.15
392	Биет хөрөнгө		4,929,597,737.85	4,812,624,370.15
39201	Барилга, байгууламж, орон сууц		5,027,748,426.00	5,027,748,426.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-471,650,107.13	-575,741,755.37
39203	Авто-тээврийн хэрэгсэл		29,562,500.00	9,428,894.37
39204	Хуримтлагдсан элэгдэл		-29,562,500.00	-9,428,894.37
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		387,450,496.16	271,136,510.36
39206	Хуримтлагдсан элэгдэл		-188,470,075.80	-86,328,290.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		207,849,126.84	160,625,217.16
39208	Хуримтлагдсан элэгдэл		-100,539,518.82	-54,809,809.02
39214	Бусад үндсэн хөрөнгө		12,361,159.55	12,361,159.55
39215	Хуримтлагдсан элэгдэл		-7,368,276.01	-8,600,456.05
39217	Ном		62,216,507.06	66,233,367.93
393	Биет бус хөрөнгө		38,478,500.19	38,416,000.00
39301	Программ хангамж		1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-1,437,499.81	-1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		38,416,000.00	38,416,000.00
II	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		4,968,076,238.04	4,851,040,370.15
III	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		5,163,160,954.25	5,064,585,220.03
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	9	1,292,572.44	47,443.10
413	Өглөг		1,292,572.44	47,443.10
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		1,292,572.44	47,443.10
IV	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		1,292,572.44	47,443.10
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		5,161,868,381.81	5,064,537,776.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,052,161,520.45	1,052,161,520.45
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		1,052,161,520.45	1,052,161,520.45
512	Хуримтлагдсан үр дүн		1,368,404,004.63	1,271,073,399.75
5121	Өмнөх үеийн үр дүн		1,368,404,004.63	1,368,404,004.63
5122	Тайлант үеийн үр дүн			-97,330,604.88
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,741,302,856.73	2,741,302,856.73
V	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		5,161,868,381.81	5,064,537,776.93
VI	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		5,163,160,954.25	5,064,585,220.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он 1324100015 9055436
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,823,620,553.51</b>	<b>2,086,193,189.47</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,554,932,300.00	1,803,672,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,554,932,300.00	1,803,672,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	268,688,253.51	282,520,789.47
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	268,688,253.51	282,520,789.47
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>112,185,886.93</b>	<b>53,726,178.50</b>
120	Нийтлэг татварын бус орлого	112,185,886.93	53,726,178.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	926,800.00	2,020,496.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	926,800.00	720,200.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,300,296.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	97,216,363.69	48,724,951.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	14,042,723.24	2,980,731.50
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,935,806,440.44</b>	<b>2,139,919,367.97</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,888,183,148.58	2,232,956,882.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,836,186,068.58	2,165,574,062.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,168,753,151.77	1,418,126,334.39
210101	Үндсэн цалин	738,855,594.80	831,786,249.15
210102	Нэмэгдэл	363,853,276.97	477,418,565.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт		25,390,000.00
210104	Урамшуулал	66,044,280.00	83,531,520.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,226,443.17	175,074,978.40
210201	Тэтгэврийн даатгал	99,444,228.81	119,175,727.74
210202	Тэтгэмжийн даатгал	11,669,182.85	14,266,525.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,382,121.41	7,153,419.09
210204	Ажилгүйдлийн даатгал	5,729,184.33	6,831,833.40
210205	Эрүүл мэндийн даатгал	23,001,725.77	27,647,472.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,847,753.51	281,020,789.47
210301	Гэрэл, цахилгаан	17,373,800.00	36,548,035.96
210302	Түлш, халаалт	241,572,753.51	241,572,753.51
210303	Цэвэр, бохир ус	2,901,200.00	2,900,000.00
2105	Нормативт зардал	52,337,570.00	60,108,743.00
210502	Хоол, хүнс	52,337,570.00	60,108,743.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,065,600.00	
210604	Урсгал засвар	2,065,600.00	

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,857,555.66	13,165,099.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,018,984.00	720,200.00 1324100015 9055436
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,838,571.66	12,444,899.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,097,994.47	218,078,117.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,336,359.00	38,895,259.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,260,000.00	8,450,130.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	151,501,635.47	170,732,728.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,997,080.00	67,382,819.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,997,080.00	67,382,819.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,982,280.00	50,177,388.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,014,800.00	17,205,431.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,888,183,148.58	2,232,956,882.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	47,623,291.86	-93,037,514.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,293,090.13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		4,293,090.13
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-4,293,090.13
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	47,623,291.86	-97,330,604.88

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,824,547,353.51	2,088,213,685.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	926,800.00	2,020,496.00
120	Нийтлэг татварын бус орлого	926,800.00	2,020,496.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	926,800.00	2,020,496.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	926,800.00	720,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,300,296.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,823,620,553.51	2,086,193,189.47
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,554,932,300.00	1,803,672,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,554,932,300.00	1,803,672,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	268,688,253.51	282,520,789.47

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	268,688,253.51	282,520,789.47
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,750,496,625.88</b>	<b>2,086,121,916.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,750,496,625.88</b>	<b>2,066,121,916.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,697,874,584.11</b>	<b>2,005,932,764.88</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,168,104,837.26</b>	<b>1,419,371,463.73</b>
210101	Үндсэн цалин	711,400,197.65	833,031,378.49
210102	Нэмэгдэл	386,841,659.61	477,418,565.24
210103	Унаа хоолны хөнгөдөлт		25,390,000.00
210104	Урамшуулал	69,862,980.00	83,531,520.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>145,736,315.45</b>	<b>175,365,892.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	98,351,312.45	119,466,642.12
210202	Тэтгэмжийн даатгал	11,846,103.00	14,266,525.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,923,400.00	7,153,419.09
210204	Ажилгүйдлийн даатгал	5,923,400.00	6,831,833.40
210205	Эрүүл мэндийн даатгал	23,692,100.00	27,647,472.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>260,669,586.74</b>	<b>281,020,789.47</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,373,800.00	36,548,035.96
210302	Түлш, халаалт	240,394,586.74	241,572,753.51
210303	Цэвэр, бохир ус	2,901,200.00	2,900,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>59,892,030.00</b>	<b>63,506,930.00</b>
210502	Хоол, хүнс	59,892,030.00	63,506,930.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,840,500.00</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	6,840,500.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,032,555.66</b>	<b>13,165,099.90</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,018,984.00	720,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,013,571.66	12,444,899.90
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,598,759.00</b>	<b>52,002,589.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,923,159.00	43,971,689.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,675,600.00	8,030,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52,622,041.77</b>	<b>60,189,151.80</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,622,041.77	60,189,151.80
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,178,166.77	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,429,075.00	42,983,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,014,800.00	17,205,431.80
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>74,050,727.63</b>	<b>22,091,768.79</b>

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	56,459,000.00	9,265,000.00
	Дотоод эх үүсвэрээр	56,459,000.00	9,265,000.00
222001	Тоног төхөөрөмж	51,259,000.00	
223001	Бусад хөрөнгө	5,200,000.00	9,265,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-56,459,000.00	-9,265,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,591,727.63	12,826,768.79
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		68,297,706.01
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		81,124,474.80

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	1,368,404,004.63	5,161,868,381.81
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн есөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			-97,330,604.88	-97,330,604.88
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	1,271,073,399.75	5,064,537,776.93

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	2,132,715,903.00	2,086,193,189.47	46,522,713.53	97.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,839,189,303.00	1,803,672,400.00	35,516,903.00	98.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,839,189,303.00	1,803,672,400.00	35,516,903.00	98.1
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	68,297,697.00		68,297,697.00	0.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	293,526,600.00	282,520,789.47	11,005,810.53	96.3
132001	Орон нутгийн төсвөөс	293,526,600.00	282,520,789.47	11,005,810.53	96.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		2,020,496.00	-2,020,496.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		720,200.00	-720,200.00	

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,300,296.00	-1,300,296.00	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,201,013,600.00</b>	<b>2,088,213,685.47</b>	<b>474,624,221.54</b>	<b>94.9</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,201,013,600.00	2,075,386,916.68	125,626,683.32	94.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,133,067,200.00	2,015,197,764.88	117,869,435.12	94.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,486,608,200.00</b>	<b>1,419,371,463.73</b>	<b>67,236,736.27</b>	<b>95.5</b>
210101	Үндсэн цалин	852,643,700.00	833,031,378.49	19,612,321.51	97.7
210102	Нэмэгдэл	553,704,100.00	477,418,565.24	76,285,534.76	86.2
210104	Урамшуулал	80,260,400.00	83,531,520.00	-3,271,120.00	104.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>186,185,400.00</b>	<b>175,365,892.78</b>	<b>10,819,507.22</b>	<b>94.2</b>
210201	Тэтгэврийн даатгал	126,606,100.00	119,466,642.12	7,139,457.88	94.4
210202	Тэтгэмжийн даатгал	14,894,800.00	14,266,525.99	628,274.01	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,447,400.00	7,153,419.09	293,980.91	96.1
210204	Ажилгүйдлийн даатгал	7,447,400.00	6,831,833.40	615,566.60	91.7
210205	Эрүүл мэндийн даатгал	29,789,700.00	27,647,472.18	2,142,227.82	92.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>291,973,000.00</b>	<b>281,020,789.47</b>	<b>10,952,210.53</b>	<b>96.2</b>
210301	Гэрэл, цахилгаан	40,420,000.00	36,548,035.96	3,871,964.04	90.4
210302	Түлш, халаалт	248,653,000.00	241,572,753.51	7,080,246.49	97.2
210303	Цэвэр, бохир ус	2,900,000.00	2,900,000.00		100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>82,140,300.00</b>	<b>63,506,930.00</b>	<b>18,633,370.00</b>	<b>77.3</b>
210502	Хоол, хүнс	82,140,300.00	63,506,930.00	18,633,370.00	77.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>		<b>100.0</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00		100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>19,821,000.00</b>	<b>14,705,099.90</b>	<b>5,115,900.10</b>	<b>74.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,041,500.00	720,200.00	321,300.00	69.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,779,500.00	13,984,899.90	4,794,600.10	74.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,839,300.00</b>	<b>59,727,589.00</b>	<b>5,111,711.00</b>	<b>92.1</b>
<b>210901</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56,223,400.00</b>	<b>51,696,689.00</b>	<b>4,526,711.00</b>	<b>91.9</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,615,900.00	8,030,900.00	585,000.00	93.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>67,946,400.00</b>	<b>60,189,151.80</b>	<b>7,757,248.20</b>	<b>88.6</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,946,400.00	60,189,151.80	7,757,248.20	88.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,631,600.00	42,983,720.00	7,647,880.00	84.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,314,800.00	17,205,431.80	109,368.20	99.4
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>2,201,013,600.00</b>	<b>2,075,386,916.68</b>	<b>125,626,683.32</b>	<b>94.3</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		68,297,706.01	-68,297,706.01	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		81,124,474.80	-81,124,474.80	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1		1	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40	40		100.0
6	Удирдах ажилтан	1	1		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	22	22		100.0
8	Үйлчлэх ажилтан	17	17		100.0

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 403,104.0 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Худалдан авсан 9,265.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлын дансаар тусгаж тайлагнасан,
- ТАЦНС-ээр бодогдсон цалинг санхүүгийн тайлангийн Си Ту Эс программд шууд татуулахгүйгээр гараар оруулахдаа бичилтийг дүн зөрүүтэй буруу хийснээр цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ, ажиллагсадтай хийх тооцооны дансууд зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө хэсэгт орлогыг 361,824.3 мянган төгрөгөөр давхардуулан тусгаж орлогыг зөрүүтэй илэрхийлсэн;
- Худалдан авсан 720.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн,
- Санхүүгийн тайлангийн Си Ту Эс программд зардлын дансыг буруу сонгож бичилт хийснээс 30,313.0<sup>1</sup> мянган төгрөгийн зардал, 981.5 мянган төгрөгөөр бараа материалын үлдэгдэл дутуу илэрхийлэгдсэн,
- Жилийн эцэст төсвийн тодотголоор хийгдсэн өөрчлөлтийг санхүүгийн тайланд тусгаагүй,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт болон УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" стандарт болон "Толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 115,149.5 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>1</sup> илэрснээс 110,549.5 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, сахилгын шийтгэл, оногдуулах 2 албан шаардлага, 4,600.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 110,549.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 91,667.7 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Дотуур байранд суудаг сурагчдын хоолны болон үдийн цай хөтөлбөрийн зардлын 110,258.6 мянган төгрөгийн бүртгэж орлого, зарлагын хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бүртгэлгүй, хүнсний материал гэж нэгтгэн тайлагнаснаас зардлын хэмнэлт, хэтрэлтийг тооцох боломжгүй нөхцөл үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бараа материалын хөдлөл өөрчлөлтийг тухай бүр хийж, нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 290.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөр тооцоог урьдчилан хянаж өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ын өр төлбөр үүсгэсэн, нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Эрхэлсэн ажлаа хангалтгүй гүйцэтгэсэн тул Төрийн аудитын тухай хуулийн Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “... албан үүргээ биелүүлээгүй ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу эд хариуцагч Б.Батцэцэг, нягтлан бодогч Н.Энхчимэг нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Илрүүлэлт:** 2025 оны 8 дугаар сард аймгийн Боловсролын газраас өгсөн 1,400.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг, самбар, БЕГ-аас хандив тусламжаар ирсэн 3,200.0 мянган төгрөгийн үнэтэй 40 ширхэг ширээ зэрэг нийт 4,600.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2 дэх “ Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хандив тусламжаар ирсэн хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Худалдан авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлын дансаар тусгаж тайлагнасан.	1	9,265.0			1	9,265.0	1	9,265.0				
ТАЦНС-ээр бодогдсон цалинг санхүүгийн тайлангийн Си Ти Эс программд шууд татуулахгүйгээр гараар оруулахдаа бичилтийг дүн зөрүүтэй буруу хийснээр цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ, ажиллагсадтай хийх тооцооны дансууд зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1		1				1					
Худалдан авсан үндсэн хөрөнгийг орлогод авалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн.	1	720.2			1	720.2	1	720.2				
Санхүүгийн тайлангийн Си Ти Эс программд зардлын дансыг буруу сонгож бичилт хийснээс зардал болон хөрөнгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдсэн	1	31,294.5			1	31,294.5	1	31,294.5				
Жилийн эцэст төсвийн тодотголоор хийгдсэн өөрчлөлтийг санхүүгийн	1		1				1					

тайланд тусгаагүй, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө хэсэгт орлогыг давхардуулан тусгаж орлогыг зөрүүтэй илэрхийлсэн;	1	361,824.3			1	361,824.3	1	361,824.3				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>403,104.0</b>	<b>2</b>		<b>4</b>	<b>403,104.0</b>	<b>6</b>	<b>403,104.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотуур байранд суудаг сурагчдын хоолны болон үдийн цай хөтөлбөрийн зардлыг бүртгэж орлого, зарлагын хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бүртгэлгүй, хүнсний материал гэж нэгтгэн тайлагнасан	1	110,258.6			1	110,258.6					1	
Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ын ер төлбөр үүсгэсэн	1	290.9			1	290.9						
Хандив ирсэн хөрөнгийг орлогоор бүртгээгүй	1	4,600.0					1	4,600.0				
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй	2								2			
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>115,149.5</b>			<b>2</b>	<b>110,549.5</b>	<b>1</b>	<b>4,600.0</b>	<b>2</b>			

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагдсан	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	1					1		